



## МОНГОЛЫН ХУУЛЬЧДЫН ХОЛБООНЫ ЗӨВЛӨЛИЙН ХУРЛЫН ТОГТООЛ

2023 оны 03 сарын 25 өдөр

Дугаар 03

Улаанбаатар хот

Г

### Журам батлах тухай

Г

Хуульчийн эрх зүйн байдлын тухай хуулийн 45 дугаар зүйлийн 45.1.4 дэх заалт, 48 дугаар зүйлийн 48.9.12 дахь заалт, 48.10 дахь хэсэг, Монголын Хуульчдын холбооны дүрмийн 4.10 дугаар зүйлийн 1 дэх хэсгийг тус тус үндэслэн Хуульчдын холбооны зөвлөлөөс ТОГТООХ нь:

- Монголын Хуульчдын холбооны “Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах журам”-ыг хавсралтаар баталсугай.
- Энэ тогтоолыг 2023 оны 03 дугаар сарын 25-ны өдрөөс эхлэн дагаж мөрдсүгэй.

ХУРАЛ ДАРГАЛАГЧ



П.ОДГЭРЭЛ

8119414  
9021110023 ГСТ7260

Монголын Хуульчдын холбооны зөвлөлийн 2023 оны 03 дугаар сарын 25.-ний өдрийн хурлын 03 дугаартай тогтообын 1 дугаар хавсралт

**ХУУЛЬЧДЫН ЭРХ, ХУУЛЬ ЁСНЫ АШИГ СОНИРХЛЫГ ХАМГААЛАХ ЖУРАМ**

**НЭГДҮГЭЭР БҮЛЭГ  
НИЙТЛЭГ ҮНДЭСЛЭЛ**

- 1.1. Энэхүү журмын зорилго нь хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тийм үйл ажиллагааг дэмжих замаар хуульчдын нэр хүндийг өргөх, хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааг эрхлэн хэрэгжүүлэх явцад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, ажил хэргийн нэр хүндэд халдсан аливаа үйлдлийг өргөдөл, гомдол, мэдээлэл, эсхүл хуульчдын нэгдсэн сонирхол хөндөгдсөн нөхцөлд өөрийн санаачилгаар болон Монголын Хуульчдын холбооны /цаашид “Хуульчдын холбоо” гэх/ хүсэлтээр судлан дүгнэлт, шийдвэр гаргахтай холбоотой харилцааг зохицуулахад оршино.
- 1.2. Хуульчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах нь хүний эрх, эрх чөлөөг хамгаалах баталгаа мөн.
- 1.3. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд Монгол Улсын Үндсэн хууль, Хуульчийн эрх зүйн байдлын тухай хууль, Өмгөөллийн тухай хууль, Хүний хувийн мэдээлэл хамгаалах тухай болон бусад хууль тогтоомжийг удирдлага болгоно.

**ХОЁРДУГААР БҮЛЭГ  
ХАМРАХ ХҮРЭЭ, ЗАРЧИМ**

- 2.1. Энэхүү журмаар дараах Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, нэр төр, ажил хэргийн нэр хүндэд халдсан үйлдлийг шалгуулахаар ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг хүлээн авах, дүгнэлт гаргах, шийдвэрлэхтэй холбоотой харилцааг зохицуулна. Үүнд:
  - 2.1.1. Шүүгчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулсантай холбоотой;
  - 2.1.2. Прокурорын мэргэжлийн үйл ажиллагаа явуулсантай холбоотой;
  - 2.1.3. Өмгөөлөгчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулсантай холбоотой;
  - 2.1.4. Нотариатчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулсантай холбоотой;
  - 2.1.5. Бусад хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулсантай холбоотой;
- 2.2. Энэ журмын 2.1-д зааснаас бусад Хуульчдын нэгдсэн сонирхлыг хөндсөн аливаа үйлдэл, эс үйлдлийг хорооны гишүүний санаачилгаар судлан шийдвэрлэж болно.
- 2.3. Энэхүү журмыг хэрэгжүүлэхэд дараах зарчмыг баримтална.
  - 2.3.1. Хуульчийн эрх, эрх ашиг, мэргэжлийн үйл ажиллагааны хараат бус байдлыг нэн тэргүүнд хамгаалах;
  - 2.3.2. Холбоо болон хорооны хараат бус, бие даасан байдлыг хамгаалах;
  - 2.3.3. Шударга ёсыг эрхэмлэх;
  - 2.3.4. Ил тод, нээлттэй байх ;
  - 2.3.5. Ашиг сонирхлыг зөрчлөөс ангид байх;

**ГУРАВДУГААР БҮЛЭГ  
ХУУЛЬЧДЫН НИЙТЛЭГ ЭРХ, ҮҮРЭГ**

- 3.1. Хуульчдын Холбооны гишүүн хуульчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол, мэргэжлийн үйл ажиллагаа, нэр төр, ажил хэргийн нэр хүнд зөрчигдсөн гэж үзвэл өргөдөл, гомдол, мэдээлэл гаргах эрхтэй.
- 3.2. Хуульч нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа явуулахдаа бусад хуульчдын мэргэжлийн үйл ажиллагаа, нэр төр, ажил хэргийн нэр хүндэд хүндэтгэлтэй хандаж, хуульчийн мэргэжлийн ёс зүйг чанд баримтлан ажиллах үүрэгтэй.

**ДӨРӨВДҮГЭЭР БҮЛЭГ  
ХОРООНЫ ҮЙЛ АЖИЛЛАГАА**

- 4.1. Хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах хороо /цаашид Хороо гэх/ нь хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, үйл ажиллагааг дэмжих, энэхүү журмын 2.1-д заасан асуудлаар ирүүлсэн өргөдөл, гомдол, мэдээллийг шийдвэрлэнэ.
- 4.2. Хорооны хуралдаан нь нийт гишүүдийн дийлэнх олонх ирснээр хүчин төгөлдөр болох ба шийдвэр нь хуралдаанд оролцсон нийт гишүүдийн олонх дэмжсэн нөхцөлд хэрэгжинэ.
- 4.3. Хорооны хуралдааны шийдвэр тогтоол хэлбэртэй байна.

**ТАВДУГААР БҮЛЭГ  
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ СУДЛАН  
ШИЙДВЭРЛЭХ АЖЛЫН ХЭСЭГ БАЙГУУЛАХ**

- 5.1. Хорооны шийдвэрээр ажлын хэсгийг хорооноос нэг гишүүн болон холбооны бусад сайн дурын хороодын төлөөллийг оролцуулсан байдлаар 3-5 гишүүнтэйгээр байгуулна.
- 5.2. Ажлын хэсэг нь Прокурорын эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл Улсын ерөнхий прокурорын газрын төлөөлөл, Өмгөөлөгчийн эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл Өмгөөлөгчдийн хорооноос тус бүр хоёр гишүүний оролцоог хангасан байна.
- 5.3. Шаардлагатай тохиолдолд нотариатч, бусад хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхол зөрчигдсөн гэж үзвэл тэдгээрийн төлөөлөл оролцсон ажлын хэсэг байгуулж болно.
- 5.4. Тухайн шийдвэрлэж буй асуудалтай ашиг сонирхлын зөрчилтэй бол ажлын хэсгийн гишүүн нь сайн дураар татгалзан гарах үүрэгтэй.
- 5.5. Ажлын хэсгийн гишүүн тухайн өргөдөл, гомдол, мэдээллийг хянан дүгнэлт гаргахтай холбоотой үйл ажиллагаа нь өөрийн хариуцсан ажил, хуулиар тогтоосон чиг үүрэгтэй давхцах, зөрчилдөх зэргээс бусад ашиг сонирхлын шууд хамааралгүй асуудлаар татгалзан гарах, үндэслэлгүйгээр ажлын хэсгийн бүрэлдэхүүнээс гарахыг хориглоно.
- 5.6. Ажлын хэсгийн гишүүний энэ журмын 5.4-д заасан үндэслэлээр гаргасан хүсэлтийг Хорооны дарга хүлээн авч, ажлын 3 өдрийн дотор шийдвэрлэнэ.

**ЗУРГААДУГААР БҮЛЭГ  
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЭЛ ХҮЛЭЭН АВАХ,  
БҮРТГЭХ, ХУВААРИЛАХ**

- 6.1. Хуульч өөрийн мэргэжлийн үйл ажиллагаа, хуульчийн нэр төр, ажил хэргийн нэр хүндэд халдсан асуудлаар Хороонд өргөдөл, гомдол гаргана.
- 6.2. Хуульчийн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндсөн асуудлаар аливаа этгээд хороонд мэдээлэл гаргаж болно.
- 6.3. Энэ журмын 6.1, 6.2-т заасан өргөдөл, гомдол, мэдээллийг Монголын Хуульчдын холбооны Тамгын газрын бичиг хэргийн ажилтан хүлээн авч бүртгэн, Хуульчдын холбооны удирдлагад даруй танилцуулж, цохолт хийлгэж шилжүүлсний дараа Хороо хариуцсан мэргэжилтэн нэгдсэн бүртгэл хөтөлж, Хорооны даргад хүргүүлнэ.
- 6.4. Хорооны дарга энэхүү журмын 5 дугаар зүйлд заасны дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүн томилж хуваарилна.
- 6.5. Хорооны дарга өргөдөл, гомдол, мэдээлэл нь тодорхой нэр хаяггүй, хорооны чиг үүрэгт илтэд харьяаллын бус тохиолдолд хүлээн авахгүй.
- 6.6. Хорооны гишүүн хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, үйл ажиллагааг дэмжих, энэхүү журмын 2.1-д заасан асуудлаар өөрийн санаачилгаар судлан дүгнэлт гаргахаар Хорооны даргад санал гаргаж болно.
- 6.7. Ажлын хэсэг ирүүлсэн өргөдлийг 30 хүртэлх өдрийн хугацаанд судлан үзэж, дүгнэлт гарган Хорооны хуралдаанаар хэлэлцүүлэхээр хүргүүлнэ.
- 6.8. Шаардлагатай гэж үзвэл ажлын хэсгийн судалгаа явуулах хугацааг Хорооны дарга ажлын 10 өдрийн хугацаагаар сунгаж болно.
- 6.9. Хорооны дарга ажлын хэсгийн дүгнэлтийг үндэслэн тухайн асуудал хуульчдын эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хөндөгдөөгүй гэж үзвэл энэ тухай бичгээр өргөдөл, гомдол, мэдээлэл гаргагчид хариу мэдэгдэнэ.
- 6.10. Өргөдөл, гомдол, мэдээлэл гаргагч нь энэ журмын 6.9-д заасан хариуг хүлээн зөвшөөрөхгүй гэж үзвэл хүлээн авснаас хойш 7 өдрийн дотор Хуульчдын холбооны Ерөнхийлөгчид гомдол гаргана.
- 6.11. Хуульчдын холбооны Ерөнхийлөгч гомдлыг хүлээн авахаас татгалзаж шийдвэрлэсэн бол энэ нь тухайн асуудлын хувьд эцсийн шийдвэр байна.
- 6.12. Өргөдөл, гомдол, мэдээлэлд дурдсан асуудал нь эрх бүхий байгууллагад шалгагдаж буй тохиолдолд Хуульчийн мэргэжлийн үйл ажиллагааны эрх зүйн баталгааг сануулсан мэдэгдлийг холбогдох эрх бүхий байгууллагад хүргүүлнэ.
- 6.13. Хороо өргөдөл, гомдол, мэдээллийг үндэслэлгүйгээр өөр байгууллага, албан тушаалтанд шилжүүлэх, шийдвэрлэхгүй дарагдуулахыг хориглоно.

**ДОЛООДУГААР БҮЛЭГ  
ӨРГӨДӨЛ, ГОМДОЛ, МЭДЭЭЛЛИЙГ ШИЙДВЭРЛЭХ АЖИЛЛАГАА**

- 7.1. Хорооны гишүүн өргөдөл, гомдол, мэдээлэл гаргагчтай уулзах, санал хүсэлтийг нь сонсох, холбогдох хүн, байгууллага, албан тушаалтнаас тайлбар, баримт бичиг, гаргуулж авахаар албан бичиг хүргүүлэх, холбогдох материалтай танилцах зэргээр өргөдөл, гомдол, мэдээлэлд дурдсан асуудлыг нэг бүрчлэн судална.
- 7.2. Өргөдөл, гомдол, мэдээлэл гаргагч нь өөрийн хүсэлтээр хорооны хуралдаанд тайлбар хийх, гишүүдийн асуултад хариулах хэлбэрээр оролцож болно.
- 7.3. Хороо нь ажлын хэсгийн ирүүлсэн дүгнэлттэй танилцаж дараах шийдвэрийг бичгээр гаргана. Үүнд:

- 7.3.1. Өргөдөл, гомдол, мэдээлэлд дурдсан асуудал нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, нэр төр, ажил хэргийн нэр хүндэд халдсан болохыг тогтоох;
  - 7.3.2. Өргөдөл, гомдол, мэдээлэлд дурдсан асуудал нь хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа, нэр төр, ажил хэргийн нэр хүндэд халдаагүй болохыг тогтоох;
- 7.4. Хорооны хуралдаанаас энэ журмын 7.3.1-д заасан шийдвэр гарсан тохиолдолд дараах арга хэмжээнээс сонгон авч хэрэгжүүлнэ:
  - 7.4.1. Хуульчийн эрх, хууль ёсны ашиг сонирхолд халдсан иргэн, хуулийн этгээдэд залруулга хийх хугацаатай мэдэгдэл, шаардлагыг бичгээр хүргүүлэх;
  - 7.4.2. Олон нийтийн мэдээллийн хэрэгслээр мэдэгдэл, уриалга гаргах, ярилцлага өгөх;
  - 7.4.3. Хэвлэлийн бага хурал зохион байгуулж, мэдээлэл өгөх;
  - 7.4.4. Зөрчлийн болон эрүүгийн хэрэг үүсгэн шалгуулахаар эрх бүхий байгууллагад харьяаллын дагуу шилжүүлэх;
  - 7.4.5. Хуульчийн зөрчигдсөн эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалахад өмгөөлөл, хууль зүйн туслалцаагаар хангах.
- 7.5. Хорооны шийдвэрийг хороо хариуцсан мэргэжилтэн өргөдөл, гомдол, мэдээлэл гаргагчид мэдэгдэнэ.

#### **НАЙМДУГААР БҮЛЭГ СТРАТЕГИЙН ӨМГӨӨЛӨЛ**

- 8.1. Хороо нь бусад хороотой хамтран хуульчдын нийтлэг эрх, хууль ёсны ашиг сонирхлыг хамгаалах, тийм үйл ажиллагааг дэмжих, энэхүү журмын 2.1-д заасан асуудлаар стратегийн өмгөөлөл үзүүлэх ажиллагааг зохион байгуулж болно.

#### **ЕСДҮГЭЭР БҮЛЭГ БУСАД БАЙГУУЛЛАГАТАЙ ХАРИЛЦАХ**

- 9.1. Ажлын хэсэг ирсэн өргөдөл, гомдол, мэдээллийг судлах, дүгнэлт гаргахтай холбоотой асуудлаар Хуульчдын холбооны тамгын газраар дамжуулан бусад байгууллагатай харилцана.

#### **АРАВДУГААР БҮЛЭГ ХЭВЛЭЛ МЭДЭЭЛЭЛ, ОЛОН НИЙТТЭЙ ХАРИЛЦАХ**

- 10.1. Хороо гаргасан шийдвэрээ Хуульчдын холбооны Ерөнхийлөгчид тухай бүр танилцуулж, шаардлагатай тохиолдолд олон нийтэд мэдээлнэ.
- 10.2. Олон нийтэд мэдээлэх ажлыг Хуульчдын холбооны Тамгын газрын дарга зохион байгуулна.
- 10.3. Хороо нь өргөдөл, гомдол, мэдээллийн шийдвэрээс бусад өөрийн үйл ажиллагаатай холбоотой мэдээллийг олон нийтэд тогтмол хүргэж байна.

#### **АРВАН НЭГДҮГЭЭР БҮЛЭГ САНХҮҮЖИЛТ**

- 11.1. Хорооны үйл ажиллагааны зардлыг Хуульчдын холбоо хариуцна.

- 11.2. Ажлын хэсгийн гишүүдэд ажлын үр дүнг харгалзан, урамшуулал олгох асуудлыг Хорооны даргын саналыг үндэслэн Тамгын газар тухай бүр шийдвэрлэнэ.

**АРВАН ХОЁРДУГААР  
БУСАД**

- 12.1. Өргөдөл, гомдол, мэдээллийг шийдвэрлэсэн материалыг хорооны мэргэжилтэн архивын нэгж болгоно.
- 12.2. Энэхүү журмыг 2023 оны ... сарын ...-ны өдрөөс эхлэн дагаж мөрдөнө.

---ооо---